

ТА УДАХГҮЙ ТӨРӨХ ҮҮ?

Төрөх эмнэлэгт хэвтэх жирэмсэн
эхчүүдэд зориулсан мэдээлэл



Hôpitaux
Universitaires
Genève

ЭМНЭЛЭГТ ХЭВТЭХИЙН ӨМНӨ

Эрүүл мэндийн даатгал ба түүний тусламж үйлчилгээ

Хэрвээ та болон таны нярай хүүхэд ЛаМал (Эрүүл мэндийн даатгалын хууль)-ын эрүүл мэндийн даатгалд хамаарагдахгүй бол та өөрийн эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эмнэлэгт хэвтэх үеийн үйлчилгээний зардал, санхүүжилтийн талаар лавлана уу. Түүнчлэн олон ортой өрөө, хагас болон бүтэн хувийн тохилог өрөөний зардыг даах эсэхийг лавлана уу.

Эрүүл мэндийн даатгалын картаа авчирна уу.

Эмнэлэгт хэвтэхэд юу бэлтгэх вэ? (жирэмсний 7 сараас эхлэн бэлтгэх)

Ээж нь

- ▶ оо, сойз гэх мэтийн хувийн ариун цэврийн хэрэгслүүд
- ▶ Төрсөн эмэгтэйчүүдэд зориулсан дотоож (slip en filet maternité), том размер ын
- ▶ Углааш
- ▶ Унтлаганы хувцас, халад
- ▶ Хөхүүл эмэгтэйчүүдийн хувцас (ур талдаа онгойдог)
- ▶ Хөхүүл эмэгтэйчүүдийн даруулга (жирэмсний сүүлийн сард хэрэглэж байснаас нэг размер илүү)
- ▶ Ариун цэврийн хэрэглэл
- ▶ Оймс
- ▶ Уруул чийгшүүлэгч
- ▶ Нүүр сэрүүцүүлэх усан шүршигч

Нярай хүүхдэд

- ▶ Дотуур хувцас
- ▶ Баривч
- ▶ Унтлаганы хувцас
- ▶ Малгай
- ▶ Бойтог эсвэл оймс

ЭМНЭЛЭГТ ХЭВТЭХ ЯВЦАД БОЛОН ДАРААХ ҮЕД

Төрөх тасаг

Таны хэвтэх өрөөнд тантай хамт зөвхөн нэг л хүн (нөхөр, хамтран амьдрагч, ар гэр, ойр дотнын хүн) орох боломжтой.

Өрөө

Таны өрөө цоожлогддог шкафтай. Өөрийн хувийн эд зүйлээ хулгайд алдах юм уу гээсэн тохиолдолд Женевийн их сургуулийн эмнэлэг ямар ч хариуцлага хүлээхгүй. Төрөх эмнэлэгт их хэмжээний мөнгө болон үнэт зүйлээ авчирхаас зайлсхийн үү.

Хоол

Хоолны цэсийн дагуу, өглөөний цай 7:30 д, өдрийн хоол 11:15 д, оройн хоол 18:00 н цагт.

Таныг эмнэлэгт байх хугацаанд манай сувилагч нар таны асуусан бүх асуултад хариулах бөгөөд эмнэлгээс гарахад хэрэгтэй мэдээллээр хангах болно (хөхүүлэх зөвлөгөө, биеэ нөхөн сэргээх, жирэмслэлтээс хамгаалах, бэлгийн харьцаа).

Төрсний дараах Эргэлтийн цаг нь хуваарь

Эргэлтийн цаг нь 12:30 - 15:30 ба 18:30 - 19:30 (хүүхдийн эцэг нь 10:00 - 21:00). Хагас болон бүтэн хувийн өрөөний үйлчлүүлэгчийг 10:00 - 20:00 эргэж болно.


Төрсний бүртгэл


Шинэ төрсөн хүүхдийг “Төрсний бүртгэлд” бүртгүүлэх нь эцэг эхийн хариуцлага .

Хэрвээ та энэ бүртгэлд хэрэгцээтэй бүх бичиг баримт эх үрсийн эмнэлэгт бүрдүүлж өгвөл, энэ бүртгэлийг таны өмнөөс хийж болно. Төрөх эмнэлэгт таныг анх ирж уулзалахад танд бүх хэрэгтэй мэдээлэл агуулсан нэгэн дугтуй өгсөн.

Иргэний бүртгэлийн газар

Rue de la Mairie 37, 1211 Genève 6

 022 418 66 31 (төрсний бүртгэл)

 022 418 66 32 (эцэг хүлээн зөвшөөрөх)

Гэртээ харих үед

Эмэгтэйчүүдийн эмч ба хүүхдийн эмчийн зөвшөөрлийн дагуу та эмнэлэгээс өглөөний 11:00 цагаас өмнө гарч болно. Таны сонгосон, гэрээр асрах хувийн эх баригчтай манай байгууллага холбоо барьж өгөх ба таны бүх хэрэгцээтэй мэдээллүүдийг дамжуулах болно. Энэ үйлчилгээг таны эрүүл мэндийн даатгал даах ёстой бөгөөд, та өөрийн эрүүл мэндийн даатгалын байгууллагатай холбоо барьж дэлэгрэнгүй мэдээлэл авна уу.

Тодотгол: Хэрэв таны нэхэмжлэл дээр “өвчтэй хүүхэд” гэж бичигдсэн бол, энэ нь таны нярай хүүхдийн асаргааны зардал юм. Энэ үйлчилгээний зардал нь манай байгууллагийн тооцооны системд тодорхойлогдсон байдаг.

Машинаар

Хүүхдийн аюулгүй байдлыг хангахын тулд төрөх эмнэлэгээс гаргангуутаа хүүхдээ автомашинд авч явахдаа зориулалтын хамгаалалтын суудал дээр зорчих хэсэг рүү нуруугаар нь харуулан суулгаж авч явах ёстой.

Мэдээлэл

Төрөх эмнэлэг (Maternité)

☎ 022 372 68 16

Эх барихын түргэн тусламжийн тасаг (Urgences obstétricales)

☎ 022 372 42 36

Жирэмсэний хяналт

☎ 022 372 42 26

Préparation à la naissance (PAN)

📍 www.hug-ge.ch/pan

Төрсний бүртгэлийн алба (Женевийн их сургуулийн эмнэлэгтэй холбоо барих)

☎ 022 372 63 92

Төрөх эмнэлэгтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг дараах веб сайтаас авна уу

📍 www.hug-ge.ch/obstetrique


📍 www.hug-ge.ch/obstetrique/faq

Service d'obstétrique

Bd de la Cluse 30
1205 Genève

Accès

Tram 12 et 18
arrêt « Augustins »
Bus 35, arrêt
« Maternité-pédiatrie »



Энэхүү танилцуулгыг Женевийн Их Сургуулийн Эмнэлгийн эмэгтэйчүүд, эх барих тасаг болон үйлчлүүлэгч, ойр дотны хүмүүсийн мэдээллийн бүлэг хамтран бэлтгэв.